



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84,  
E-mail: info@frc.mn, http://www.frc.mn

2023.07.07 № 2 / 2906  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Санал авах тухай

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийг 2023 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна. Энэ хуульд заасан мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогыг тодорхойлох, зохицуулах, холбогдох төрийн байгууллагын үйл ажиллагааг уялдуулах зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны дэргэд орон тооны бус Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлийг байгуулсан бөгөөд тус зөвлөл нь мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн үйл ажиллагаанд хэрэглэх зээлийн, барьцааны, батлан даалтын гэрээний ерөнхий загварыг батлах, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох аргачлалыг батлах чиг үүргийг хүлээсэн.

Хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооноос боловсруулан хүргүүлж байгаа мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн үйл ажиллагаанд хэрэглэх зээлийн, барьцааны, батлан даалтын гэрээний ерөнхий загвар, зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох аргачлалын төсөлд саналаа ирүүлж, мэргэжлийн туслалцаа үзүүлж хамтран ажиллахыг хүсье.

Хавсралт: 11 хуудастай.

ДЭД ДАРГА



Н.ХҮДЭРЧУЛУУН

## ЗЭЭЛИЙН ГЭРЭЭ

202 ... оны ... сар ... өдөр

Дугаар

хот /аймаг/

Энэхүү зээлийн гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г нэг талаас ..... /хот, аймаг/ дахь .....” ХХК (цаашид Зээлдүүлэгч гэх), нөгөө талаас /иргэн, хуулийн этгээд/-ийн бүртгэлтэй ..... хаягт оршин суух ..... регистрийн дугаартай ..... ХХК, ..... овогтой ..... (цаашид Зээлдэгч гэх) нар (хамтад нь Талууд гэх) Монгол Улсын Иргэний хууль, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах хууль, бусад холбогдох хууль, журмыг үндэслэн харилцан тохиролцож дараах нөхцөлтэйгөөр байгуулсан болно.

## НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 Энэхүү гэрээний зорилго нь Зээлдүүлэгч тодорхой хэмжээний мөнгөн хөрөнгийг хугацаатай, хүүтэй, барьцаатай, эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр Зээлдэгчид зээлдүүлэх, буцаан төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэхүү зээлийн гэрээнд заасан нэр томъёог дараах утгаар ойлгоно.
  - 1.2.1 Зээлийн хүү -Зээлийг ашигласан хугацаанд гэрээнд заасан хэмжээгээр тооцох зээлийн хариу төлбөрийг,
  - 1.2.2 Зээлийн эргэн төлөх хуваарь – Зээлийн эргүүлэн төлөх хэмжээ, хүүгийн хэмжээ, хугацааг заасан талуудын тохиролцоог,
  - 1.2.3 Нэмэгдүүлсэн хүү – үндсэн хүүгийн 20 хувиас хэтрэхгүй байхыг,
  - 1.2.4 Барьцаа – Зээлдэгчээс зээлээ буцаан төлөх баталгаа болгож Зээлдүүлэгчид барьцаалуулж байгаа зээлдэгчийн болон батлан даагчийн хууль ёсны өмчийг,

## ХОЁР. ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ

- 2.1 Зээлийн хэмжээ: ..... /тоогоор/ ...../үсгээр/
- 2.2 Зээлийн үндсэн хүү: ..... % /1 сарын/
- 2.3 Зээлийн барьцааны гэрээний хугацаа: ..... сар /тоогоор/, ..... /бичгээр/ сар буюу .....-ээс ..... -ы өдөр хүртэл
- 2.4 Зээлийн төрөл: .....
- 2.5 Зээлийн эргэн төлөлтийн хуваарь: Зээлийн хүүг зээлдэгчид зээлийн олголт хийсэн өдрөөс эхлэн тооцно. Зээлийн эргэн төлөх хуваарьт бүх нийтээр амрах баяр ёслолын өдөр таарсан тохиолдолд өмнөх ажлын өдөрт шилжүүлэн төлнө.
- 2.6 Зээлдэгч өөрийн дансанд мөнгө хүлээн авахыг зөвшөөрч, гарын үсэг зурснаар тухайн дансанд мөнгө хүлээн авах эрх баталгаажна.
  - 2.6.1 Зээлдүүлэгчийн мөнгө хүлээн авах дансны дугаар: .....
  - 2.6.2 Банкны нэр: .....
  - 2.6.3 Данс эзэмшигчийн нэр: .....

## ГУРАВ. БАРЬЦААНЫ ЭРХ, ЗҮЙЛ

- 3.1 Барьцааны эрх: Барьцаалагч, барьцаалуулагч хооронд бичгээр гэрээг байгуулснаар үүснэ.

3.2 Барьцаа хөрөнгө: Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд барьцаа хөрөнгийг зээлдэгчтэй харилцан тохиролцож, бодитой үнэлнэ.

3.3 Барьцааны зүйл: Барьцаалуулагч гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар өөрийн өмчлөлийн болон эрхийн зөрчилгүй эд хөрөнгө гэдгийг хүлээн зөвшөөрч баталгаажуулсан барьцаа байна.

3.4 Барьцааны үнэлгээг тухайн үеийн зах зээлийн ханштай уялдуулан тогтоосон ханш, барьцааны зүйлийн онцлог шинжээс хамаарч тогтооно.

3.5 Барьцааны зүйлийн өмчлөл, түүнтэй холбогдон гарах гуравдагч этгээдийн аливаа маргаанд Зээлдүүлэгч хариуцлага хүлээхгүй.

#### **ДӨРӨВ. ЗЭЭЛДҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

4.1 Зээлдүүлэгчээс олгох зээл нь хүүтэй ба зээлийн гэрээг бичгээр хийж, гэрээнд зээлийн хүүгийн хэмжээг тодорхой тусгах үүрэгтэй.

4.2 Үндсэн зээл, зээлийн хүүгээ гэрээнд заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд хуульд болон гэрээнд заасан арга хэмжээ авах

4.3 Зээлдүүлэгч зээлийн ашиглалт, зориулалт, эргэн төлөлтөнд хяналт тавих, зээлээ төлөхгүй хугацаа хэтэрсэн тохиолдолд нэмэгдүүлсэн хүүг тооцох, шаардлагатай арга хэмжээ авах

4.4 Зээлдүүлэгч нь зээлдэгч зээлээ төлсөн тохиолдолд барьцааны эзэмших эрхийг зээлдэгчид шилжүүлэх үүрэгтэй.

4.5 Зээлтэй холбоотой аливаа төлбөр тооцоо бүртгэлийг үнэн зөв гүйцэтгэж баталгаажуулна.

#### **ТАВ. ЗЭЭЛДЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

5.1 Зээлдэгч гэрээ байгуулах, барьцаа хөрөнгөнд өөрчлөлт оруулах, барьцаа хөрөнгөө хүлээж авахдаа өөрийн биеэр иргэний үнэмлэхтэйгээ /цахим/ ирнэ.

5.2 Зээлийн эргэн төлөлтийн хуваарьт өдрөөс өмнө төлөлт хийх тохиолдолд ашигласан хугацаагаар зээлийн хүүг төлнө.

5.3 Зээлдэгч зээлийн мөнгөн дүнд өөрчлөлт оруулж болох бөгөөд барьцаа хөрөнгийн үнэлгээний үнийн дүнгийн хүрээнд нэмэлт болон хасалт хийж өөрчлөлт оруулж болно.

5.4 Зээлдэгч нь зээлдүүлэгчээс зээлж авсан мөнгийг гэрээнд заасан хугацаанд буцаан төлөх үүрэгтэй ба энэхүү үүргээ биелүүлээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үнийн дүнгийн тодорхой хувиар зээлдүүлэгчид нэмэгдүүлсэн хүү төлнө.

5.5 Зээлдэгч гэрээг дуусгавар болгосноор барьцааны зүйлийг хүлээн авах ба итгэмжлэгдсэн төлөөлөгч мөн хүлээн авч болно.

#### **ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ**

6.1 Энэхүү гэрээ нь Монгол Улсын хууль тогтоомжид үндэслэн хийгдсэн бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол гэрээний зүйл заалтыг нэн тэргүүнд баримтална.

6.2 Гэрээний үүргийн биелэлтийн явцад гарсан маргаан, дотоод хяналтын шалгалтаар зөрчил илэрсэн тохиолдолд талууд харилцан хэлэлцээр хийх замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

6.4 Энэхүү гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах нөхцөлд түүнийг гагцхүү бичгээр үйлдэж, талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

6.5 Байгалийн давагдашгүй хүчин зүйл болон гэнэтийн ослын улмаас барьцаалсан эд хөрөнгийн бүрэн бүтэн байдалд гарч болзошгүй элэгдэл хорогдол, учирсан хохирлыг Зээлдэгч бүрэн хариуцна.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН**

**Зээлдүүлэгчийг төлөөлж:**

**Зээлдэгчийг төлөөлж:**

**Зээлийн мэргэжилтэн**

**Зээлдэгч**

..... /...../

..... /...../

Гарын үсэг

Овог, нэр

Гарын үсэг

Овог, нэр

**БАРЬЦААНЫ ГЭРЭЭ**

202... оны ... дүгээр  
сарын ... өдөр

..... хот /аймаг/

Энэхүү **БАРЬЦААНЫ ГЭРЭЭ** (цаашид "Гэрээ" гэх)-г нэг талаас ..... (цаашид Барьцаалагч гэх), нөгөө талаас ..... иргэний бүртгэлтэй ..... хаягт оршин суух ..... регистрийн дугаартай ..... овогтой ..... (цаашид Барьцаалуулагч гэх) нар (хамтад нь Талууд гэх) Монгол Улсын Иргэний хууль, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийг үндэслэн харилцан тохиролцож байгуулав.

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1 Энэ гэрээгээр ..... өдөр талуудын байгуулсан ..... тоот зээлийн гэрээний үүргийн биелэлтийг хангах зорилгоор барьцаалуулагчаас зээлийн барьцаанд барьцаалуулж буй эд зүйл, үүнээс үүдэн гарч буй эрх зүйн харилцааг зохицуулна.
- 1.2 Барьцааны гэрээний хугацаа зээлийн гэрээг байгуулсан цагалбартай адил байна.
- 1.3 Барьцаа хөрөнгийг зээлдэгчтэй харилцан тохиролцож, бодитой үнэлнэх ба барьцаагаар хангах шаардлагын хэмжээ ..... байна.

**ХОЁР. БАРЬЦААНЫ ЗҮЙЛ**

- 2.1 Барьцаалуулагч нь дээрх зээлийн гэрээний барьцаа болгож доорхи хөрөнгийг холбогдох баримт бичгийн хамт хүлээлгэн өгнө. Үүнд:

№	Барьцаа хөрөнгийн талаархи мэдээлэл	Тайлбар
1.	Барьцаа хөрөнгийн нэр төрөл, зориулалт	
2.	Өмчлөгчийн эцгийн нэр, нэр.	
3.	Барьцаа хөрөнгийн үнэлгээ	
4.	Барьцаа хөрөнгийн гэрчигээ, баримт бичгийн дугаар	
5.	Барьцаа хөрөнгийн тоо ширхэг	
6.	Барьцаа хөрөнгийн шинж тэмдэг	
7.	Барьцаа хөрөнгийг барьцаалсан бүртгэлийн дугаар	
8.	Барьцааны зүйлийг эзэмшилдээ байлгах тал	

9.	Бусад	
10.		
11.		

### ГУРАВ: БАРЬЦААЛУУЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1 Барьцаалуулсан хөрөнгөөр үндсэн зээл, зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүүгийн төлбөр, гэрээний үүргийн биелэлт хангахтай холбогдон гарсан зардлыг тооцно.
- 3.2 Барьцааны хөрөнгийн бүрэн бүтэн байдал, эзэмшилтэй холбоотой баримт бичгийн бүрдэл, холбогдох материалыг барьцаалагч хариуцна.
- 3.3 Иргэний хуулийн 159.2-т заасны дагуу барьцаалуулагч шаардсан бол барьцааны зүйлийг худалдахын өмнө түүний үнэлгээг шинжээчээр тогтоолгож болох бөгөөд холбогдох зардлыг барьцаалуулагч хариуцна.
- 3.4 Барьцаалуулагч нас барсан, гэнэтийн тохиолдлоор эрх зүйн чадамжгүй болсон нөхцөлд барьцаа хөрөнгийг захиран зарцуулах эрх, үүрэг нь Монгол Улсын Иргэний хуулийн дагуу түүний хууль ёсны өв залгамжлагчид шилжинэ.

### ДӨРӨВ. БАРЬЦААЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1 Барьцаалагч нь Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан цахим мэдээллийн санд бүртгэгдсэн эд зүйлсийг барьцаанд авахаас татгалзах эрхтэй.
- 4.2 Барьцаалагч нь Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3-т заасан сэжиг бүхий эд зүйлсийн талаар цагдаагийн байгууллагад даруй мэдэгдэх үүрэгтэй.
- 4.3 Барьцаалагч нь барьцаалуулагчийн барьцааны хөрөнгийн бүрэн бүтэн байдал болон эзэмшлийн байдалд хяналт тавих, шаардлагатай асуудлаар санал солилцох эрхтэй.
- 4.4 Барьцаалсан хөрөнгийг зээлийн барьцаанд байх хугацаанд барьцаалагч тал гуравдагч этгээдэд эзэмших эрхийг шилжүүлэхгүй байх үүрэгтэй.
- 4.5 Барьцааны хөрөнгийг гэрээний хугацаанд барьцаалагчийн зөвшөөрөлгүйгээр худалдах, бэлэглэх, барьцаалах, батлан даалт гаргах зэргээр гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй байх үүрэгтэй.
- 4.6 Барьцаалагч нь гэрээний үүргээ биелүүлээгүй зээлдэгчид барьцааны эрх хэрэгжүүлэх мэдэгдлийг хүргүүлэх бөгөөд барьцааны шаардлагыг хангах эцсийн боломжит хугацаа нь барьцааны эрх хэрэгжүүлэх мэдэгдлийг барьцаалуулагчид хүргүүлснээс, эсхүл гэрээнд заасны дагуу мэдэгдсэнээс хойш 14 хоног байна.
- 4.7 Барьцаалуулагч нь Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д заасан хугацаанд гэрээний үүргийг хангаагүй бол барьцаалагч барьцааны зүйлийг Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд заасан журмын дагуу худалдан борлуулж, уг орлогоос барьцааны шаардлагыг хангаж, үлдсэн хэсгийг барьцаалуулагчид олгох үүрэгтэй.
- 4.8 Барьцаалуулагч төлбөрийг бүрэн төлж дуусгасан нөхцөлд барьцааны эзэмших эрхийг барьцаалуулагчийн нэр дээр нь шилжүүлэн өгөх үүрэгтэй.

### ТАВ.БУСАД

5.1 Барьцааны гэрээг 2 хувь үйлдэж барьцаалагч, барьцаалуулагч тус тус 1 хувийг хадгална.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

**БАРЬЦААЛАГЧ:**

Гарын үсэг \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /

Хаяг \_\_\_\_\_

\_\_\_\_\_

Утас \_\_\_\_\_

/Тамга/

**БАРЬЦААЛУУЛАГЧ:**

Гарын үсэг \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /

Хаяг \_\_\_\_\_

\_\_\_\_\_

Утас \_\_\_\_\_

/Тамга/

## БАТЛАН ДААЛТЫН ГЭРЭЭ

20..оны..сарын...-ний өдөр

№ ....

Улаанбаатар хот

## Нэг. Ерөнхий зүйл

Энэхүү гэрээг нэг талаас /Үүрэг гүйцэтгүүлэгч гэх/ нөгөө талаас.....овогтой...../РД: ...../Батлан даагч гэх/ нар Монгол улсын Иргэний хуулийн 458-р зүйлийг үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож тус гэрээг байгуулав.

- 1.1. Энэхүү гэрээгээр Батлан даагч тал нь “Үүрэг гүйцэтгүүлэгч” болон “Үүрэг гүйцэтгэгч” нарын хооронд байгуулагдсан 20..оны..сарын...-ний өдрийн...тоот гэрээний дагуу Үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэж чадна гэдгийг баталж, Хэрэв гэрээний үүргээ зөрчсөн, үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд энэхүү гэрээгээр тохиролцсон хэмжээгээр үүрэг хүлээх гэрээний нөхцөлийг хүлээн зөвшөөрөв.
- 1.2. Батлан даалтын дээд хэмжээ.../тоогоор/.../үсгээр/ төгрөгийн үнийн дүн бүхий байх ба үүрэг гүйцэтгэгч гэрээнд заасны дагуу үүргээ гүйцэтгэх чадваргүй болсон, нас барсан тохиолдолд батлан даалтын үнийн дүнг болон гэрээ дуусгавар болохтой холбоотой зардлыг батлан даагч хариуцна.
- 1.3. Батлан даагчийн хүлээсэн үүрэг нь үүрэг гүйцэтгэгчээс үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хүлээсэн үүрэгт хамаарна.

## Хоёр. Батлан даагчийн чиг үүрэг

- 2.1 Батлан даагч нь өөрийн хүсэлтээр энэхүү гэрээний батлан даалт болж байгаа тул энэхүү гэрээг нэг талын санаачлагаар цуцлах, гэрээгээр хүлээсэн үүргээсээ татгалзах эрхгүй
- 2.2 Үүрэг гүйцэтгүүлэгчээс батлан даагчид шаардлага гаргавал үүрэг үүрэг гүйцэтгэгчээс үүрэг гүйцэтгүүлэгчийн эсрэг гаргах бүх татгалзлыг батлан даагч гаргах эрхтэй
  - 2.2.1. Үүрэг гүйцэтгүүлэгч гэрээг биелүүлээгүй
  - 2.2.2. Үүрэг гүйцэтгэгч мөнгөн төлбөрийн үүргээс өөр үүргийг гүйцэтгэх боломжгүй болсон.
  - 2.2.3. Үндсэн үүргийн хөөн хэлэлцэх хугацаа дуусгавар болсон.
  - 2.2.4. Өөрчлөгдөх болзол бий болсноор үндсэн үүрэг хүчин төгөлдөр бус болсон.
- 2.4 Үүрэг гүйцэтгүүлэгчийн эсрэг гаргаж болох татгалзлаасаа үүрэг гүйцэтгэгч татгалзсан ч батлан даагч татгалзах эрхээ алдахгүй.

## Гурав. Гэрээг дуусгавар болгох буюу түүнийг цуцлах

- 3.2 Энэхүү гэрээнд заасан батлан даалтын үнийн дүн бүхий төлбөр дуусгавар болсон тохиолдолд Батлан даагчийн үүрэг дуусгавар болно.
- 3.3 Батлан даагч хөрөнгийн чадваргүй болж болзошгүй байдал үүссэн гэж үүрэг гүйцэтгүүлэгч үзсэн
- 3.4 Хяналтын явцад үүрэг гүйцэтгэгч барьцаа хөрөнгийн чанар эрс муудаж байгаан тогтоогдсон
- 3.5 Үүрэг гүйцэтгэгчийн өмч хөрөнгө санхүүгийн байдлын талаар бусад хуулийн этгээдээс маргаан үүсгэсэн буюу эрх бүхий байгууллагаас тогтоогдсон



### Дөрөв. Маргаан шийдвэрлэх

4.1 Энэхүү гэрээг хэрэгжүүлэх явцад гараг аливаа маргааныг “Үүрэг гүйцэтгүүлэгч” болон “Үүрэг гүйцэтгэгч” нар хэлэлцээр хийх замаар шийдвэрлэнэ.

4.2 Хэлэлцээр хийх замаар шийдвэрлэгдээгүй тохиолдолд маргааныг шүүхийн журмаар шийдвэрлэнэ.

### Тав. Бусад зүйл

5.1 Энэхүү гэрээн нь зээлийн гэрээний салшгүй хэсэг болох бөгөөд үүрэг гүйцэтгүүлэгч болон үүрэг гүйцэтгэгч нар гэрээнд заасан үүргийг биелүүлэх үүрэгтэй бөгөөд заалтыг зөрчвөл зээлийн гэрээг зөрчсөнтэй адилтган үзнэ.

### Гэрээ байгуулсан:

Үүрэг гүйцэтгүүлэгчийг төлөөлж:  
“.....” ХХК-ний ...../...../  
.....  
Хаяг:.....  
Утас:.....

Батлан даагчыг төлөөж:  
.....овогтой...../...../  
.....  
Хаяг:.....  
Утас:.....

## МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮҮГИЙН ХЭМЖЭЭГ БОДОХ, ТООЦОХ АРГАЧЛАЛ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү аргачлалын зорилго нь мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн хүүгийн хувь хэмжээг бодох, тооцох аргачлалыг батлах, хяналт тавих, харилцагчдын эрх ашгийг хамгаалахад оршино.

### Хоёр. Зээлийн хүү тооцох

- 2.1 Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс гэрээний үндсэн дээр зээлдэгчид олгосон мөнгөн хөрөнгийг ашигласны хариу төлбөр буюу үнийг “Хүү” гэж тооцох ба зээлийн хүүг ашигласан хугацаагаар ердийн хүүгээр тооцно.
- 2.2 Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5-д заасны дагуу нэмэгдүүлсэн хүүгийн хэмжээг тооцохдоо үндсэн хүүгийн 20 хувиас хэтрүүлэхгүй байна.

#### 1. Ердийн хүү

“Ердийн хүү” гэж үндсэн дүнгээс тооцсон хүүгийн хэмжээг хэлнэ. Ердийн хүүг бодохдоо:

$$\text{Хүү} = \text{Үндсэн дүн} * \text{Хүүгийн хувь} * \text{Хугацаа} / 365$$

$$I = P * R * T / 365$$

I – Хүү

P – Үндсэн зээлийн дүн

R – Хүүгийн хувь

T – Хугацаа (хуанлийн хоногоор)

Жишээ 1 : 1,000,000₮-ийг сарын 7.5 %-ийн хүүтэй зээлдүүлсэн бол 1 сарын хүү нь:

$$\text{Хүү} = 1,000,000 \text{ ₮} * 0.075 * 30 / 365 = 6,150₮$$

Жишээ 2: (9 хоногийн ашигласан хугацаагаар тооцсон хүү):

$$\text{Хүү} = 1,000,000₮ * 0.075 * 9 / 365 = 1,845 \text{ ₮} \quad \text{гэх мэт.}$$

#### 2. Нэмэгдүүлсэн хүү

“Нэмэгдүүлсэн хүү” гэж гэрээнд заасан хугацаанд зээлийн үндсэн төлбөрийг эргүүлэн төлөөгүй тохиолдолд Иргэний хуульд заасан хувиас хэтрэхгүй хувь хэмжээгээр үндсэн хүүг нэмэгдүүлж тооцсон хүүгийн хувь хэмжээг ойлгоно.

Нэмэгдүүлсэн хүүг бодохдоо:

Нэмэгдүүлсэн хүүгийн хэмжээ = Хугацаандаа төлөгдөөгүй зээлийн дүн\*Хүүгийн хувь\*Нэмэгдүүлсэн хүүгийн хувь\*Хугацаа хэтэрсэн хоног

$$I = P * R * R_i * T / 365$$

I- Нэмэгдүүлсэн хүүгийн хэмжээ

P- Хугацаандаа төлөгдөөгүй зээлийн дүн

R -Хүүгийн хувь хэмжээ

R<sub>i</sub>-Нэмэгдүүлсэн хүүгийн хувь (20 хувиас хэтрүүлэхгүй)

T- Хугацаа хэтэрсэн хоног

Жишээ: 1,000,000₮-ийг 4 сарын (120 хоног) хугацаанд сар бүр тэнцүү хуваан төлөх нөхцөлтэй сарын 7.5 %-ийн хүүтэй зээлдүүлсэн бөгөөд хэрэв авсан зээлээ хугацаанд нь төлөөгүй тохиолдолд зарласан хүүгийн 20 хувьтай тэнцэхүйц хэмжээний нэмэгдүүлсэн хүү төлөхөөр тохиролцсон. Зээлдэгч эхний сард эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөх байсан 250,000₮-ийг заасан хугацаандаа төлөөгүй бөгөөд төлбөрийг 18 хоногийн дараа хийсэн бол банкны зүгээс тооцож авах нэмэгдүүлсэн хүүгийн хэмжээг дараах байдлаар бодно.

$$\text{Нэмэгдүүлсэн хүүгийн хэмжээ: } I_1 = 250,000₮ * 0.075 * 0.2 * (18/365) = 183.75₮$$

### Гурав. Мэдээллийн ил тод байдал

- 3.1 Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд, иргэн нь Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлөөс тогтоосон зээлийн хүүгийн дээд хэмжээг ерөнхий танилцуулга, мэдээллийг үнэн зөв гарган өөрийн цахим хуудас, болон мэдээллийн самбарт байршуулж нийтэд ил тод мэдээлнэ.
- 3.2 Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд, иргэн нь Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор хууль, тогтоомжид нийцүүлэн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой мэдээлэл, эрхийн гэрчилгээг нийтэд ил харагдахуйц байршуулна.
- 3.3 Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд, иргэн нь харилцагчид зээлийн төлбөрийг хугацаанаас нь өмнө хэсэгчлэн төлөх тохиолдолд зээлдэгчийн төлөх хүүгийн хэмжээ, зээлийн хугацаанд орох өөрчлөлтийг тайлбарлана.
- 3.4 Мөнгөн зээлийн үйл ажиллагааны гэрээний үсгийн фонд 9-с багагүй, тодорхой, ойлгомжтой байна.
- 3.5 Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд, иргэн нь харилцагчид мөнгөн зээл олгохдоо зээлийн хүү, барьцаа хөрөнгийн үнэлгээг бүрэн гүйцэд тайлбарлах үүрэгтэй.

### Дөрөв. Хяналт, хариуцлага

- 4.1 Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд, иргэн нь Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-т заасны дагуу Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд энэ хуулийн 17.4.2-т заасныг зөрчиж зээлийн гэрээ

байгуулсан бол зээлийн хүүгийн дээд хэмжээнээс хэтэрсэн дүнгээр хүү авах эрхээ алдана.

- 4.2 Зээлийн хүүг олгох зээлийн дүнгээс суутгах эсхүл ирээдүйд хуримтлуулах хүүг зээл олгохоос өмнө урьдчилаж төлүүлэх, энэ зорилгоор эх үүсвэр дансанд байршуулахыг хориглоно.
- 4.3 Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд санаатай болон болгоомжгүй үйлдлээр зээлдэгчид хор хохирол учруулсан бол хохирлыг бүрэн барагдуулна.
- 4.4 Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд, иргэн холбогдох хуульд заасны дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.
- 4.5 Энэхүү аргачлалын хэрэгжилтэд Санхүүгийн зохицуулах хороо хяналт тавьж, аргачлалыг зөрчсөн тохиолдолд холбогдох хуулийн дагуу арга хэмжээ авна.